



**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/63.

Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны ажиллах журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад орчин цагийн уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах хүрээнд салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд 2022 оны 09 дүгээр сарын 28-наас 30-ны өдрүүдэд Орхон аймагт “Алтан бамбай-2022” аврах ажиллагааны тэмцээнийг зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, мэдүүлгийн загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдамжийн дагуу тэмцээнийг зохион байгуулах бэлтгэл ажлын ханган ажиллахыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ/Х.Бадамсүрэн/-т үүрэг болгосугай.


3. Тушаал, удирдамжийг салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэн оролцоог хангах ажлыг зохион байгуулж, тэмцээний тайлан, мэдээллийг нэгтгэн танилцуулахыг ХАБЭА-н салбар хорооны Нарийн бичгийн дарга/Н.Амартуул/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.НАНДИНЖАРГАЛ

Төрийн нарийн бичгийн даргын
2022 оны 1/8 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



“АЛТАН БАМБАЙ-2022” АВРАХ АЖИЛЛАГААНЫ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

НЭГ. Тэмцээний мэдээлэл

- 1.1. Тэмцээний нэр: “Алтан бамбай-2022”
- 1.2. Тэмцээний үндсэн агуулга: Уул уурхайн үйлдвэрлэлийн явцад гарч болзошгүй осол, аюул, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед аврах ажиллагаа явуулах.
- 1.3. Тэмцээний уриа: “Аюулгүй байдлын төлөө хамтдаа”

ХОЁР. Тэмцээний зорилго

Монгол Улсад орчин цагийн уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон олон улсын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандарт зэрэг хууль, тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, гамшгаас хамгаалах бэлэн байдал, галын аюулгүй байдлыг хангах талаар мэдлэг олгох, үйлдвэрлэлийн явцад гарч болзошгүй осол аюул, онцгой нөхцөл байдал, гал түймэр, гамшигтай тэмцэх, аврах ажиллагаа явуулах талаар чадвар эзэмшүүлэх, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, галын сайн дурын бүлгэм, анхны тусламжийн нөхөрлөл болон бусад туслах хүчний томилгоот бүрэлдэхүүнийг дадлагажуулах, чадавхижуулах, туршлага олгоход оршино.

ГУРАВ. Тэмцээний хамрах хүрээ

- 3.1. Тэмцээний ерөнхий зохион байгуулагчид:
 - Уул уурхайн, хүнд үйлдвэрийн яам;
 - Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр анги;
 - “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ.
- 3.2. Тэмцээнд оролцогчид:
 - Тэмцээнд уул уурхай салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бүх төрлийн аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрийн бүтэц, нэгж;
 - Тэмцээнд оролцох хүсэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, бүтэц, нэгж нь энэ талаар албан ёсоор 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн дотор мэдүүлгээ зохион байгуулагчид ирүүлнэ.

ДӨРӨВ. Тэмцээн явагдах хугацаа, байршил

- 4.1. Тэмцээн 2022 оны 09 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйлдвэрийн талбайн Аврах ажиллагааны сургалт дадлагын байгууламж дээр явагдана.
- 4.2. Тэмцээний нээлтийн үйл ажиллагаа 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 08³⁰ цагт Аврах ажиллагааны сургалт дадлагын байгууламж дээр явагдана.
- 4.3. Тэмцээний нээлтийн үйл ажиллагаанд тэмцээний зохион байгуулагч, оролцогч байгууллагуудын төлөөлөл, баг бүрэлдэхүүн бүрэн оролцоно.

ТАВ. Тэмцээнд оролцох баг, бүрэлдэхүүн

5.1. Тэмцээнд оролцох хүсэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, бүтэц, нэгж нь энэ талаар албан ёсоор 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн дотор тэмцээний ерөнхий зохион байгуулагч нарт мэдэгдэх ба тэмцээн зохион байгуулах байршилд нэвтрэх тээврийн хэрэгслийн талаар мэдээллийг өгнө.

5.2. Тэмцээнд аж ахуйн нэгж, бүтцийн нэгжүүдээс 5.1-т заасан бүрэлдэхүүнтэй нэг багийг бүрдүүлж оролцоно.

5.3. Энэхүү удирдамжийн 5.1, 5.2-т заасан багт Онцгой байдлын байгууллагын болон аж ахуйн нэгж, байгууллагын аврах анги, аврах баг, бүлгийн алба хаагч нар буюу албан тушаал, үүргийн дагуу аврах үйл ажиллагааг гүйцэтгэдэг ажилтнуудыг оролцуулахгүй. Тэмцээнд оролцох багийг аж ахуйн нэгж, байгууллага, бүтцийн нэгжийн галын сайн дурын бүлгэм, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, анхны тусламжийн нөхөрлөл болон бусад туслах хүчний томилгоот бүрэлдэхүүний гишүүдээс бүрдүүлнэ. Баг болгон нь багийн ахлагчийг томилно.

ЗУРГАА. Тэмцээний бэлтгэл ажил

6.1. Тэмцээнд оролцох аж ахуйн нэгж байгууллага, бүтцийн нэгжүүд нь 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр хүртэл тэмцээнд оролцох багийн гишүүдэд өндөрт аюулгүй ажиллах, шатан дээр аюулгүй ажиллах, гал унтраагуурыг зөв, аюулгүй ажиллуулах болон аюулгүй ажиллагааны нийтлэг ерөнхий шаардлагын дагуу зааварчилгаа өгөх, эрүүл мэндийн үзлэгт оруулж эмчийн гарын үсэг, тамгаар баталгаажуулна. Зааварчилгаа, эрүүл мэндийн үзлэгийн үр дүнг энэхүү удирдамжийн хавсралтад заасан маягт бүхий тэмцээнд оролцох мэдүүлэгт бүртгэнэ. Тэмцээнд мэдүүлэгт орсон багийн бүрэлдэхүүнд хүндэтгэх шалтгаангүйгээр өөрчлөлт оруулах, тэмцээнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа аваагүй, эрүүл мэндийн үзлэгт ороогүй ажилтныг оролцуулахыг хориглоно.

6.2. Тэмцээний техникийн зөвлөгөөн, талбайн танилцуулга нь 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр 09⁰⁰ цагт үйлдвэрийн газрын Аврах ажиллагааны сургалт дадлагын байгууламжийн талбай дээр явагдана. Зөвлөгөөнд тэмцээний зохион байгуулах ажлын хэсэг, шүүгчид, туслахууд, оролцох багууд буюу тэмцээний үйл ажиллагаатай холбоотой бүх ажилтнууд заавал оролцоно. Зөвлөгөөн дээр тэмцээний зохион байгуулалт, явцын талаар дэлгэрэнгүй танилцуулж, багуудын оролцох дугаар, дэс дарааллыг сугалуулна. Багийн ахлагч нар нь зөвлөгөөнд ирэхдээ тэмцээнд оролцох мэдүүлгээ авчирч тэмцээний зохион байгуулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүлээлгэж өгнө.

6.3. Баг болгон нь хүснэгт №1-т заасны бэлтгэлийг хангасан байна.

Хүснэгт №1

№	Бэлтгэх зүйл, материал	Бэлтгэлийг хангах багийн гишүүд	Тоо ширхэг
1	Багийн нэр, лого бүхий самбар	Баг болгонд	1 ширхэг
2	Жигд хувцаслалт буюу нэг өнгө, загварын ажлын хувцас, гутал, бүчтэй дуулга, хамгаалалтын нүдний шил, таван хуруу бээлий	Багийн гишүүн болгон	6 ширхэг
3	Ажлын хувцасны нуруу ба энгэр дээр наасан тухайн багийн гишүүний хувийн дугаар (багийн ахлагч нь №1 дугаартай байна)	Багийн гишүүн болгон	6 ширхэг
4	Дуулганы баруун гар талд наасан тухайн багийн гишүүний хувийн дугаар (багийн ахлагч нь №1 дугаартай байна)	Багийн гишүүн болгон	6 ширхэг

5	Дуулганы зүүн гар талд наасан улаан загалмайн тэмдэг	Багийн 2 эмэгтэй гишүүн	2 ширхэг
6	Шаардлага бүрэн хангасан, цэнэгтэй, пайзтай MFZ-10 буюу 10кг-аас багагүй хэмжээний нунтаг агуулсан гал унтраагуур	Баг болгонд	3 ширхэг
7	Шаардлага бүрэн хангасан, размер хэмжээ нь таарсан, цүнхтэй газ эсэргүүцэгч	Багийн гишүүн болгон	7 ширхэг
8	Зөөврийн, бүрэн цэнэгтэй, дуулга дээр зүүдэг гэрэлтүүлэг	Баг болгонд	1 ширхэг
9	Дараах нэмэлт хэрэгсэлтэй, иж бүрэн эмийн сан: - уян бинт (160см урттай, 10см өргөнтэй); - шархан дээр тавих ариун бинт (10см*12см хэмжээтэй, 4-5-аас багагүй давхар нугалсан, ариун уутанд хийсэн); - эмнэлгийн резинэн нэг удаагийн бээлий; - чангалуур; - үзэг балтай жижиг тэмдэглэлийн дэвтэр	Баг болгонд	2 ширхэг 10 ширхэг 10 хос 1 ширхэг 1 ширхэг

ДОЛОО. Тэмцээний төрөл, явагдах журам, дүн үнэлгээ

7.1. Тэмцээн нь хүснэгт №2-т харуулсан үндсэн 4 төрлөөр явагдах ба төрөл болгоныг зохион байгуулах комиссын 2 шүүгч шүүж дүгнэнэ(төрөл болгоны гүйцэтгэлийн задаргааг хавсралтад заасан болно). Шүүгч нарт туслахууд туслаж ажиллах ба шүүж дүгнэх үйл ажиллагаанд оролцохгүй.

Хүснэгт №2

№	Төрлийн нэр
1	Зам тээврийн ослын эрэн хайх, аврах ажиллагаа
2	Барилга байгууламжийн нурангаас эрэн хайх, аврах ажиллагаа
3	Газар доорх байгууламжийн ослоос эрэн хайх, аврах ажиллагаа
4	Нуранги дах эрэн хайх, аврах ажиллагаа

7.2. Тэмцээний төрөл болгоныг багаар хийж гүйцэтгэх ба тэмцээний гол шалгуур нь багийн ажиллагаа. Багийн ахлагч нь багийн аврах ажиллагааг удирдаж, багийн гишүүдэд өгөх үүрэг, командыг чанга, тодорхой, ойлгомжтой хэлэх бөгөөд багийн гишүүдийн хамт аврах ажиллагаанд оролцоно.

7.3. Тэмцээнд оролцох баг болгон нь хүснэгт №1-т заасан бэлтгэлийг хангасан эсэхийг тэмцээн эхлэхээс өмнөх шүүгчдийн үзлэгээр тогтооно. Бэлтгэл нь хангагдаагүй шаардлага болгоныг тусгайлан авч үзэж, тэмцээнд оролцох боломжтой эсэхийг тогтооно.

7.4. Тэмцээнд оролцож буй багт дараах тохиолдолд дор заасан торгуулийг ногдуулна. Үүнд:

- Бэлтгэл нь бүрэн хангагдаагүй боловч тэмцээнд оролцох боломжтой гэж үзсэн тохиолдолд бэлтгэл нь хангагдаагүй шаардлага болгонд 5 минутын торгууль ногдуулж, багийн эцсийн дүнд нэмнэ.
- Тэмцээний нээлт, сугалсан дарааллын дагуу тухайн төрөлд оролцох хугацаанаас хоцорсон бол, төрөл болгоны аврах ажиллагааг хийж гүйцэтгэх үед гаргасан алдаа болгонд 2 минутын торгууль ногдуулж, тухайн төрлийн аврах ажиллагааг гүйцэтгэсэн хугацаан дээр нэмнэ.
- Тэмцээний талбай дээр зөвхөн аврах ажиллагаа явуулж буй багийн гишүүд, шүүгчид, туслахууд, тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсэг болон үйлдвэрийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны

сурвалжлагч нар байхыг зөвшөөрнө. Бусад багуудын гишүүд болон тэмцээн сонирхогчид тэмцээн явагдах талбай дээр байрлах, өөр бусад багуудад саад учруулах, шүүгчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож нөлөөлөхийг хориглох бөгөөд ингэх тохиолдол бүрд тухайн багт нийтийн хэв журам зөрчсөн гэх үндэслэлээр 2 минутын торгууль ногдуулж, багийн эцсийн дүнд нэмнэ.

7.5. Тэмцээний төрөл болгоны үнэлгээ, эцсийн дүнг дараах аргачлалын дагуу гаргана. Үүнд:

- Тэмцээний тухайн төрлийн шүүгч нар нь багийн тухайн төрлийн аврах ажиллагааг хийж гүйцэтгэсэн бодит хугацаан дээр 7.4-т заасан торгуулийн хугацааг нэмж, тухайн багийн төрөл болгоны үнэлгээг гаргаж, багийн ахлагчид танилцуулна.
- Тэмцээний ерөнхий шүүгч нь нийт багуудын бүх 4 төрлийн аврах ажиллагааны нийлбэр үнэлгээн дээр 7.4-т заасан торгуулийн хугацааг нэмж, нийт багуудын эцсийн дүнг гаргаж, нийтэд танилцуулна.
- Тэмцээний эцсийн дүнгээр тэмцээнийг хамгийн бага хугацаатай гүйцэтгэсэн багуудыг шалгаруулж, энэхүү удирдамжийн 8 дугаар бүлэгт заасны дагуу шагнаж урамшуулна.

НАЙМ. Тэмцээний шагнал урамшуулал

8.1. Тэмцээнд I, II, III дугаар болон тусгай 2 байр эзэлсэн нийт 5 баг, шилдэг 4 багийн ахлагч, шилдэг 4 аврагчийг Хүснэгт 3-т дурьдсан байдлаар шалгаруулж, шагнаж урамшуулна. Үүнд:

Хүснэгт 3

№	Эзэлсэн байр	Шагнал, урамшуулал	Шалгаруулалт
1	I дүгээр байр эзэлсэн баг	Цом, Өргөмжлөл, Алтан медаль, мөнгөн шагнал	Эцсийн дүн үнэлгээгээр буюу хамгийн бага хугацаагаар тооцож шалгаруулна
2	II дугаар байр эзэлсэн баг	Өргөмжлөл, Мөнгөн медаль, мөнгөн шагнал	
3	III дугаар байр эзэлсэн баг	Өргөмжлөл, Хүрэл медаль, мөнгөн шагнал	
4	Тусгай байр эзэлсэн баг	Өргөмжлөл, мөнгөн шагнал	
5	Тусгай байр эзэлсэн баг	Өргөмжлөл, мөнгөн шагнал	
6	Зам тээврийн ослын аврах ажиллагааны шилдэг багийн ахлагч, шилдэг аврагч-2 хүн	Мөнгөн шагнал	Тухайн төрлийн шүүгчдийн саналаар шалгаруулна
7	Барилга байгууламжийн аврах ажиллагааны шилдэг багийн ахлагч, шилдэг аврагч-2 хүн	Мөнгөн шагнал	
8	Газар доорх байгууламжийн аврах ажиллагааны шилдэг багийн ахлагч, шилдэг аврагч-2 хүн	Мөнгөн шагнал	
9	Нуранги дах аврах ажиллагааны шилдэг багийн ахлагч, шилдэг аврагч- 2 хүн	Мөнгөн шагнал	

8.2. Тэмцээний шагналт байр эзэлсэн баг, шилдэг аврагч нарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлана.

8.3. Энэхүү удирдамжийн 8.1-т заасан болон тэмцээний бусад зардлыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ХАБЭА-н нөхцөлийг сайжруулах иж бүрэн арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөний батлагдсан зардалаас санхүүжүүлнэ.


8.4. Тэмцээнд оролцогч байгууллага нь зохион байгууллах хороотой зөвшилцөж өөрийн нэрэмжит шагналыг гардуулж болно.

ЕС. Тэмцээний явцад гарсан зөрчил, маргаан, гаргасан санал гомдлыг таслан шийдвэрлэх

9.1. Тэмцээний явцад гарсан аливаа зөрчил, маргаан, санал гомдлыг тухайн бүрт нь багийн ахлагчийн оролцоотойгоор тэмцээний Ерөнхий шүүгч болон тухайн төрлийн аврах ажиллагааны шүүгчид хамтран шийдвэрлэнэ. Дараагийн баг тухайн төрлийн аврах ажиллагааг гүйцэтгэж эхэлсэн үед аливаа санал гомдлыг хүлээж авахгүй ба шийдвэрлэхгүй. Мөн тэмцээний эцсийн дүн үнэлгээ гарсны дараа аливаа санал гомдлыг хүлээж авахгүй ба шийдвэрлэхгүй.

9.2. Тэмцээний явцад гарсан зөрчил, маргаан, гаргасан санал гомдлыг шийдвэрлэхэд бие биенээ харилцан хүндэтгэх, хэлэлцээрээр тохиролцох зарчмыг баримтлана.

Төрийн нарийн бичгийн даргын
2022 оны 1/18 дугаар тушаалын
хөёрдугаар хавсралт



**“АЛТАН БАМБАЙ–2022”
аврах ажиллагааны тэмцээнд оролцох мэдүүлэг**

Багийн нэр: _____
Багийн ахлагч: _____

Багт оролцох хувийн дугаар	Багийн гишүүний овог нэр	Багийн гишүүний бүртгэлийн дугаар (регистрийн дугаар)	Багийн гишүүний албан тушаал	Эрүүл мэндийн үзлэг хийсэн, эрүүл эсэхийг тогтоосон эмчийн тэмдэглэл	Өгсөн ХАБЭА-н зааварчилг ааны агуулга	ХАБЭА-н зааварчилга а авсан багийн гишүүний гарын үсэг
1						
2						
3						
4						
5						
6						

_____ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН (БҮТЦИЙН НЭГЖИЙН) ХАБЭА
ХАРИУЦСАН ИНЖЕНЕР

/ ОВОГ НЭР /

_____ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН (БҮТЦИЙН НЭГЖИЙН)
ЭМЧ

/ ОВОГ НЭР /